



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 628

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг  
сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаал, 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн I/421 тоот мэдэгдэл, “Өндөрхаан инвест” хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Аргай бэст” хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Түшиг траст” хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Өндөрхаан инвест” ХХК, “Аргай бэст” ХХК, “Түшиг траст” ХХК-иудын арилжаанд оролцох эрхийг 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
- Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг. Энэ тушаалын 1-т заасан гишүүн компаниудад анхааруулсугай.
- Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР